ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# “Улаанбаатар дулаан сүлжээ” ТӨХК-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2024/13/НА-СТА-ТӨА**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | СНАГазрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Ц.Хосжаргал<br>Утас:261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn<br>Аудитор: М.Пагамдулам<br>Утас:260512 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn<br>“Голден пэйж Аудит” ХХК-ийн захирал: С.Оюунгэрэл<br>Утас:  99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/793

танай ______________-ны № _______________-т

УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.БАЯРСАЙХАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант хугацаанд Дэлхийн банкны хөрөнгөөр санхүүжүүлсэн “Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд бий болсон 5,814.8 сая төгрөг, Европын сэргээн босгох хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлсэн “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл”-ийн хүрээнд бий болсон 15,069.5 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 83, 103, 104, 108, 105 дугаар тогтоолоор худалдан авах дулааны тарифыг 3,316.3 төгрөгөөс 3,579.7 төгрөг, 113 дугаар тогтоолоор дулаан түгээх хангах үнийн тарифыг 3,460.4 төгрөгөөс 5,592.5 төгрөг болгож тус тус нэмэгдүүлсэн, 114, 116, 117 дугаар тогтоолоор тусгай зөвшөөрлүүдийн үйлчлэх хүрээнд нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Компанийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 36 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 97.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Балансын зүйл | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1.1.1 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 295,536,740.77 | 4,047,713,701.62 |
| 1.1.2 | Дансны авлага | 29,668,087,708.09 | 26,908,388,365.13 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 4,588,799.00 | 0.00 |
| 1.1.4 | Бусад авлага | 1,801,711,460.03 | 1,807,447,652.11 |
| 1.1.6 | Бараа материал | 578,421,069.22 | 569,771,784.94 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал тооцоо | 24,497,740.63 | 37,850,880.33 |
| 1.1.11 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **32,372,843,517.74** | **33,371,172,384.13** |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 279,432,759,364.18 | 317,734,442,031.63 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 2,411,081,623.14 | 2,221,950,523.78 |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 9,436,717,761.20 | 8,436,729,976.56 |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 1,970,486,120.12 | 2,226,027,654.72 |
| 1.2.10 | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **293,251,044,868.64** | **330,619,150,186.69** |
| 1.3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **325,623,888,386.38** | **363,990,322,570.82** |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 2,267,685,959.24 | 5,351,715,445.63 |
| 2.1.1.3 | Татварын өр | 1,342,916,213.91 | 1,537,284,102.22 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | 0.00 | 546,439,107.21 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 147,410,744.13 | 1,339,060,299.52 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 456,021,143.59 | 1,173,715,417.65 |
| 2.1.1.13 | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **4,214,034,060.87** | **9,948,214,372.23** |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 63,858,509,416.65 | 101,054,003,813.97 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | 2,805,651,398.66 | 2,690,563,157.00 |
| 2.1.2.6 | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **66,664,160,815.31** | **103,744,566,970.97** |
| 2.2 | **Өр төлбөрийн нийт дүн** | **70,878,194,876.18** | **113,692,781,343.20** |
| 2.3.1 | Төрийн өмч | 218,335,138,255.81 | 224,711,247,384.81 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 17,481,124,664.28 | 17,380,143,548.78 |
| 2.3.9 | Эздийн өмчийн бусад хэсэг | 8,520,372,829.00 | 2,144,263,700.00 |
| 2.3.10 | Хуримтлагдсан ашиг | 10,409,057,761.11 | 6,061,886,594.03 |
| 2.3.11 | **Эздийн өмчийн дүн** | **254,745,693,510.20** | **250,297,541,227.62** |
| 2.4 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **325,623,888,386.38** | **363,990,322,570.82** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого ( цэвэр )** | **139,434,015,670.80** | **147,616,313,956.80** |
| 2 | Борлуулалтын өртөг | 103,791,137,420.77 | 115,227,018,631.72 |
| 3 | **Нийт ашиг ( алдагдал )** | **35,642,878,250.03** | **32,389,295,325.08** |
| 5 | Хүүгийн орлого | 0.00 | 44,664,947.15 |
| 8 | Бусад орлого | 789,945,234.19 | 1,005,799,722.02 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 44,923,972.22 | 54,962,765.03 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 32,406,419,330.57 | 34,698,596,732.65 |
| 12 | Бусад зардал | 1,120,532,201.80 | 2,031,210,310.93 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз ) | 587,622.26 | (33,214.38) |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз ) | -471,520,550.19 | (489,814,190.84) |
| 18 | **Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )** | **2,390,015,051.70** | **(3,834,857,219.58)** |
| 19 | Орлогын татварын зардал | 345,698,172.49 | 0.00 |
| 20 | **Татварын дараах ашиг ( алдагдал )** | **2,044,316,879.21** | **(3,834,857,219.58)** |
| 22 | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )** | **2,044,316,879.21** | **(3,834,857,219.58)** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **208,731,008,677.41** | **17,962,229,372.48** | **11,748,393,278.40** | **7,883,636,173.70** | **246,325,267,501.99** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | |
| **Залруулсан үлдэгдэл** | **208,731,008,677.41** | **17,962,229,372.48** | **11,748,393,278.40** | **7,883,636,173.70** | **246,325,267,501.99** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | 6,376,109,129.00 | | 6,376,109,129.00 |
| Өмчид гаргасан өөрчлөлт | 9,604,129,578.40 | | (9,604,129,578.40) | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал ) | | | | 2,044,316,879.21 | 2,044,316,879.21 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | (481,104,708.20) | | 481,104,708.20 | |
| 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 218,335,138,255.81 | 17,481,124,664.28 | 8,520,372,829.00 | 10,409,057,761.11 | 254,745,693,510.20 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | 100,981,115,50 | 100,981,115.50 |
| Өмчид гаргасан өөрчлөлт | 6,376,109,129.00 | | (6,376,109,129.00) | | |
| Зарласан ногдол ашиг | | | | 613,295,063.00 | 613,295,063.00 |
| Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал ) | | | | 3,834,857,219.58 | 3,834,857,219.58 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | (100,981,115.50) | | | (100,981,115.50) |
| **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **224,711,247,384.81** | **17,380,143,548.78** | **2,144,263,700.00** | **6,061,886,594.03** | **250,297,541,227.62** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | **2022 оны 12-р сарын 31** | **2023 оны 12-р сарын 31** |
|---|---|---|---|
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **149,531,918,234.41** | **166,625,225,119.34** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 149,529,672,514.41 | 166,556,997,768.90 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 2,245,720.00 | 68,227,350.44 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **142,148,506,135.27** | **149,064,545,127.65** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 9,588,394,334.00 | 11,524,683,033.00 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 3,347,062,565.30 | 3,817,801,285.87 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 1,231,132,876.50 | 1,344,778,827.76 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 2,103,009,705.33 | 2,126,316,902.80 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 7,090,484,969.25 | 3,620,020,339.50 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 118,788,421,684.89 | 126,630,944,738.72 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **7,383,412,099.14** | **17,560,679,991.69** |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 9,187,039,774.34 | 13,808,469,816.46 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 7,315,786,271.05 | 4,942,188,777.00 |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 1,871,253,503.29 | 8,866,281,039.46 |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **9,187,039,774.34** | **13,808,469,816.46** |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 588,887.39 | 116,448.30 |
| 3.1.4 | Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг | 588,887.39 | 116,448.30 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 1,265.13 | 149,662.68 |
| 3.2.5 | Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал | 1,265.13 | 149,662.68 |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **587,622.26** | **33,214.38** |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 1,803,040,052.94 | 3,752,176,960.85 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,098,576,793.71** | **295,536,740.77** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **295,536,740.77** | **4,047,713,701.62** |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2022 он | 2023 оны | | Өөрчлөлт (2023 гүйц / 2023 төл) | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөв | Гүйц | зөрүү | хувь |
| 1 | Худалдан авах ДЭХ | мян.Жоуль | 31,297.6 | 32,864.1 | 32,189.3 | (674.8) | 2.1 |
| 2 | **Нийт орлого:** | сая.төг | **140,224.5** | **150,202.4** | **148,666.9** | **(1,535.5)** | **1.0** |
| | Борлуулалтын орлого | сая.төг | 139,434.0 | 149,635.7 | 147,616.3 | (2,019.40 | 1.3 |
| | Үндсэн бус үйл ажиллагааны орлого | сая.төг | 790.5 | 566.7 | 1,050.6 | 483.9 | 85.4 |
| | Борлуулалтын орлого цуглуулалт | сая.төг | 136,022.9 | 148,668.2 | 150,034.9 | 1,366.7 | 0.9 |
| 3 | 1 Жоуль-ын Орлого | төг/Жоуль | 4,455.1 | 4,553.2 | 4,585.9 | 32.7 | 0.7 |
| | Өөрийн өртөг | төг/Жоуль | 4,377.2 | 4,713.1 | 4,721.0 | 7.9 | 0.2 |
| 4 | **Нийт зардал:** | **сая.төг** | **137,834.5** | **155,707.3** | **152,501.7** | **(3,205.6)** | **2.1** |
| | Худалдаж авах ДЭХ-ний өртөг | сая.төг | 103,791.1 | 116,707.8 | 115,227.0 | (1,480.8) | 1.3 |
| | Түгээх,хангах үйл ажиллагааны зардал | сая.төг | 33,206.2 | 38,184.9 | 36,738.5 | (1,446.4) | 3.8 |
| | Үндсэн бус үйл ажиллагааны зардал | сая.төг | 837.2 | 814.6 | 536.2 | (278.4) | 34.2 |
| 5 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | төг | 0.98 | 1.04 | 1.03 | 0.0 | 0.5 |
| 6 | **Татварын өмнөх ашиг,алдагдал** | **сая.төг** | **2,390.0** | **(5,504.9)** | **(3,834.9)** | **(1,670.0)** | **30.3** |
| 7 | Нийт авлага: | сая.төг | 31,644.5 | 32,708.8 | 28,989.7 | (3,719.1) | 11.4 |
| | ДЭХ-ний авлага | сая.төг | 1,877.7 | 1,930.0 | 2,081.0 | 151.0 | 7.8 |
| | Бусад авлага | сая.төг | 1,801.7 | 1,801.7 | 1,807.4 | 5.7 | 0.3 |
| | Тайлант онд хэрэглэгчдээс авах авлага | сая.төг | 3,679.4 | 3,731.7 | 3,888.4 | 156.7 | 4.2 |
| | Нэхэмжлээгүй авлага | сая.төг | 27,965.0 | 28,977.1 | 25,101.3 | (3,875.8) | 13.4 |
| | Борлуулалтын авлага цуглуулалтын хувь | % | 97.6 | 99.4 | 101.6 | 2.3 | 2.3 |
| 8 | Нийт өр төлбөр | сая.төг | 70,878.2 | 117,427.9 | 113,692.8 | (3,735.1) | 3.2 |
| | Урт хугацаат өр төлбөр | сая.төг | 66,664.2 | 105,715.8 | 103,744.6 | (1,971.2) | 1.9 |
| | Богино хугацаат өр төлбөр | сая.төг | 4,214.0 | 11,712.1 | 9,948.2 | (1,763.9) | 15.1 |
| 9 | Хөрөнгө оруулалт,их засвар | сая.төг | 7,933.6 | 7,957.1 | 7,521.2 | (436.0) | 5.5 |
| 10 | Цалингийн сан | сая.төг | 12,651.6 | 14,201.3 | 14,169.2 | (32.1) | 0.2 |
| | Ажиллагсдын тоо | тоо | 387.0 | 395.0 | 388.0 | (7.0) | 1.8 |
| | Дундаж цалин /сараар/ | мян.төг | 2,724.3 | 2,996.1 | 3,043.2 | 47.2 | 1.6 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,520,051.3 мянган төгрөгийн 4 зөрчил[1] илэрснээс 814,466.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 705,585.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тус байгууллагын 12 байршилд эзэмшиж буй газрын гэрчилгээ болон санхүүгийн тайлангийн бүртгэлээрх газрын хэмжээ кадастрын зургаас нийт 46 метр квадрат газраар зөрүүтэй | 1 | 1,897.2 | | | 1 | 1,897.2 | | | | | | |
| Гэрээ байгуулсан компанитай ажлаа хүлээлцэж, гэрээний үр дүнг хянаж, хэрэгжилтийг дүгнээгүй | 1 | 705,585.1 | | | | | 1 | 705,585.1 | | | | |
| Он удаан жил насжилтаар ангилаагүй,тооцоо нийлж баталгаажуулаагүй 143.9 сая төгрөг, иргэний хэрэг түдгэлзүүлсэн 294.4 сая төгрөг, давж заалдах шатны шүүхэд 374,3 сая төгрөг нийт 812.6 сая төгрөгийн авлага байна. | 1 | 812,569.0 | | | 1 | 812,569.0 | | | | | | |
| Үлдэх өртөггүй болсон 58,368.3 сая төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлээгүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **4** | **1,520,051.3** | | | **2** | **814,466.2** | **2** | **705,585.1** | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 11,314,111.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 10,977,323.5 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 336,788.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил* | | | | | | | | |
| 3 мэдээлэл байршуулаагүй, худалдан авалт хийсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалттай холбоотой 68.8 сая төгрөгийн мэдээллийг дутуу байршуулсан | 1 | 68,850.0 | | | 1 | 68,850.0 | | |
| Дүн | 1 | 68,850.0 | | | 1 | 68,850.0 | | |
| *Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил* | | | | | | | | |
| ТУЗ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллахдаа компанийн засаглалын кодекс хэрэгжүүлэн ажиллаагүй, хяналтыг хэрэгжүүлээгүй, ТУЗ-ийн дарга гишүүд, нарийн бичгийн даргын ажлын тайлан байхгүй | 1 | | | | 1 | | | |
| Байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг боловсруулахдаа худалдан авах ажиллагааны их засварын хөрөнгө оруулалт, техникийн шинэчлэлт, мөн ажиллах хүчний цалингийн санг үндэслэлгүй, оновчтой бус боловсруулж, батлуулсан байна. Тухайлбал үндсэн цалин 6,768.6 сая төгрөг, нэмэгдэл цалин 8,125.3 сая төгрөг ба нийт цалинд нэмэгдэл, шагналт цалин | 1 | 9,728,856.1 | | | 1 | 9,728,856.1 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 дахин илүү төлөвлөсөн. Үр дүн, шагналт цалинг урьдчилж олгосон 1,513.5 сая төгрөг байна. | | | | | | | | |
| Хамтын гэрээ болон дотоод журамд заасны дагуу эрчим хүчний тэргүүний ажилтны шагналд 14.7 сая төгрөг, ахмадын зөвлөлийн цалингийн зардалд 1.2 сая төгрөг, бусад шагналд 85.5 сая төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 101,441.5 | | | 1 | 101,441.5 | | |
| Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдэх зорилгоор олгосон 28 айлын орон сууц бүртгэлтэй байгааг ТУЗ-ийн тогтоолд заасны дагуу төлбөрийн нөхцөлийг харгалзан авлага үүсгэх, зардалд шилжүүлэх асуудлыг шийдвэрлээгүй байна. | 1 | 1,078,175.9 | | | 1 | 1,078,175.9 | | |
| Ажиллагсдын цалингаас үүрэн телефоны ярианы төлбөр зэрэг хувь хүний тооцооны суутгалыг хийж, нягтлан бодогчийн чиг үүрэгт тусгагдаагүй ажлыг гүйцэтгүүлсэн. | 1 | 336,788.2 | | | | | 1 | 336,788.2 |
| Дүн | 5 | 11,245,261.7 | | | 4 | 10,908,473.5 | 1 | 336,788.2 |
| **Нийт дүн** | **6** | **11,314,111.7** | | | **5** | **10,977,323.5** | **1** | **336,788.2** |